МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны төрөл:	Лавлагаа мэдээлэл
Судалгааны код:	**СТ-25/233**
Огноо:	2025.07.04

ЗАХИАЛАГЧ:	УИХ-ын гишүүн Х.Ганхуяг
Хянасан:	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	Судалгааны хэлтсийн зөвлөх Г. Билгээ
Судлаач:	Л.Мишээлт

Улаанбаатар хот, 2025

Агуулга

УДИРТГАЛ 4

НЭГ. УЛС ОРНУУДЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ 5

1.1. ШИНЭ ЗЕЛАНД УЛС 5

1.2. ЭСТОНИ 5

1.3. ГЕРМАН 6

ХОЁР. УЛС ОРНУУДЫН (ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨС БУСАД) БҮРТГЭЛ, МЭДЭГДЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ 8

2.1. ШИНЭ ЗЕЛАНД 8

2.2. ЭСТОНИ 8

2.3. ГЕРМАН 9

ГУРАВ. ЗӨВШӨӨРӨЛ ШААРДАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 10

ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА: ЗӨВШӨӨРӨЛ ШААРДСАН САЛБАР ДАХЬ ЗӨРЧИЛ..13

4.1. ШИНЭ ЗЕЛАНД 13

4.2. ЭСТОНИ 13

4.3. ГЕРМАН 14

ТАВ. УЛС ОРНУУДЫН ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ 16

ЭХ СУРВАЛЖ 18

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. улс орнуудын зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа, эрх олгогч байгууллага.....10

Товчилсон үгийн жагсаалт

ЭЗҮАТХ	Эдийн засгийн үйл ажиллагааны тухай хууль
GEWO	Gewerbeordnung

УДИРТГАЛ

“Гадаадын зарим улсын зөвшөөрлийн эрх зүйн орчин зохицуулалт” судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Судалгааны захиалгын дагуу Шинэ Зеланд, Эстони, Герман зэрэг улс орнуудын зөвшөөрлийн эрх зүйн орчны хүрээнд бүртгэл, мэдэгдэл, тусгай зөвшөөрлийн хуулийн зохицуулалтыг судлах.

Судалгааны хамрах хүрээ: Зөвшөөрлийн эрх зүйн орчинд:

- зөвшөөрөл, мэдэгдэл шаардах үйл ажиллагаа;
- зөвшөөрөл, бүртгэл, мэдэгдлийн хуулийн зохицуулалт;
- зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын эрх, үүрэг;
- холбогдох хууль зөрчсөн тохиолдолд тооцох хариуцлага;
- мэдэгдлийн зохицуулалт (зарим үйл ажиллагааг зөвшөөрөл бус мэдэгдлийн журмаар зохицуулж буй эрх зүйн зохицуулалт)-ыг Шинэ Зеланд, Герман, Эстони зэрэг улсын хууль тогтоомжийн хүрээнд судална.

Судалгааны ажлын бүтэц: Судалгааны тайлан үндсэн таван хэсэгтэй байна. Үүнд:

1. Улс орнуудын зөвшөөрлийн хуулийн зохицуулалт
2. Улс орнуудын нэр томьёоны тодорхойлолт (зөвшөөрөл, бүртгэл, мэдэгдэл, тусгай зөвшөөрөл)
3. Улс орнуудын зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа, байгууллага
4. Улс орнуудын зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан болон зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлага
5. Улс орнуудын зөвшөөрлийн онцлог зохицуулалт

Судалгааны арга зүй: Судалгааг тухайн улсын холбогдох хууль тогтоомжид тулгуурлан судлан, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг: Зөвшөөрлийн хууль, тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл, мэдэгдэл, зөвшөөрөл олгох байгууллага

Key words: Law on licenses, license, permit, notification, competent authority of issuance

НЭГ. УЛС ОРНУУДЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ

1.1. ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Шинэ Зеланд Улсад бизнес, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан ерөнхий буюу нийтлэг тусгай зөвшөөрөл шаардах хууль тогтоомж байдаггүй. Өөрөөр хэлбэл, шинэ бизнес эхлүүлэхэд зориулсан заавал авах нэг төрлийн “ерөнхий зөвшөөрөл” гэж хуульчилсан журам байхгүй бөгөөд тухайн бизнес нь хуульд тусгайлан хориглоогүй л бол иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах эрхтэй. Энэ нь “эрх чөлөөтэй эрхлэх, харин хуульд хориглоогүй л бол” гэсэн эрх зүйн зарчимд тулгуурладаг (LegalVision,n.d.). Жишээлбэл, Шинэ Зеландын Компанийн тухай хуулийн дагуу компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулахыг хүсэгч нь компанийн бүртгэл хийлгэж, Шинэ Зеландын бизнесийн дугаар авах шаардлагатай бөгөөд энэ нь бизнесийг албан ёсоор бүртгүүлэх үйл явц юм.[1] Мөн бизнес эрхлэгч нь татварын албанд мэдэгдэж бүртгүүлэх үүрэг хүлээн, зарим салбар, үйл ажиллагаанд тусгай хуулиудын дагуу салбарын тусгай зөвшөөрөл авах шаардлагатай. Тухайлбал, архи, согтууруулах ундаа худалдах, үйлдвэрлэх үйл ажиллагаа нь “Архи, согтууруулах ундаа худалдах, нийлүүлэх тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг.[2] Хувийн хамгаалалтын болон мөрдөх үйлчилгээний тухай хууль нь хамгаалалтын ажил, мөрдөгчийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй эрхлэхийг шаардсан байдаг.[3] Иймхүү Шинэ Зеланд улсад бизнесийн үйл ажиллагааны цогц зөвшөөрлийн хууль байхгүй боловч тодорхой өндөр эрсдэлтэй эсвэл олон нийтийн ашиг сонирхол хөндөгддөг салбар бүрт тусгай хууль тогтоомжийн хүрээнд зөвшөөрлийн зохицуулалттай байна. Үүний зэрэгцээ мэргэжлийн үйлчилгээний салбарт хуулийн дагуу мэргэжлийн байгууллагад бүртгүүлэх шаардлагыг тогтоосон байдаг байна (International Trade Administration, 2023).

1.2. ЭСТОНИ

Эстони Улс нь эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагаанд хамаарах зөвшөөрлийн нэгдсэн зохицуулалт бүхий хуулийг баталсан байна. Тодруулбал, Эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий хуулийг баталж, энэ хуулиар эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх ерөнхий нөхцөл, журмыг тогтоосон.[4] Тус хуульд аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааны эрх чөлөөг хангах үндсэн зарчим, түүнд тавих хязгаарлалтыг зохицуулсан бөгөөд хуульд тусгайлан заасан тохиолдолд л зөвшөөрөл эсвэл мэдэгдлийн шаардлага ногдуулахаар тогтоожээ (§4). Өөрөөр хэлбэл, Эстонид эдийн засгийн үйл ажиллагааны эрх чөлөө нь үндсэн зарчим бөгөөд зөвхөн олон нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдалд нөлөөлөхүйц

---

[1] Шинэ Зеланд: Companies Act 1993, §12. Хандах: https://www.legislation.govt.nz/act/public/1993/0105/latest/DLM319570.html?search=qs_act%40bill%40regulation%40deemedreg_companies+act+1993_resel_25_h&p=1&sr=1

[2] Шинэ Зеланд: Sale and Supply of Alcohol Act 2012, §7. Хандах: https://www.legislation.govt.nz/act/public/2012/0120/latest/DLM3339333.html

[3] Шинэ Зеланд: Private Security Personal and Private Investigators Act 2010, §23. Хандах: https://www.legislation.govt.nz/act/public/2010/0115/latest/DLM1594432.html?search=qs_act%40bill%40regulation%40deemedreg_Private+Security+Personnel+and+Private+Investigators+Act+2010_resel_25_h&p=1&sr=1

[4] Эстони: General Part of the Economic Activities Code Act. Хандах: https://www.riigiteataja.ee/en/eli/522082014004/consolide#:~:text=%C2%A7%201

тохиолдолд уг эрхийг хязгаарлаж, тухайн үйл ажиллагаанд зөвшөөрөл авах эсвэл мэдэгдэл гаргахыг шаарддаг байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий хууль нь ямар үйл ажиллагаанд зөвшөөрөл авах шаардлагатай, ямар тохиолдолд мэдэгдэл хүргүүлж бүртгүүлэхэд хангалттайг ерөнхийд нь зохицуулж, мөн тодорхой салбарын хуулиар эрх зүйн зохицуулалтыг хангажээ. Хуулийн 1 дүгээр зүйлд эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх эрх чөлөө, түүнийг хэрэгжүүлэх ерөнхий журам, нөхцөлийг тогтоохоос гадна үйл ажиллагаа эхлүүлэх, түр зогсоох, сэргээх, бүртгэл хөтлөх, хяналт тавих болон хариуцлагын асуудлыг зохицуулах талаар тусгасан байдаг. Хуулийн 2 дугаар зүйлд энэ хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлохдоо бүх төрлийн аж ахуйн нэгж, бүх салбарт хамаарах хэдий ч бусад хуульд өөрөөр зохицуулсан онцгой салбаруудад хамаарахгүй гэж заасан байдаг.

Ийнхүү Эстони улсын зөвшөөрлийн зохицуулалт нь нэгдсэн нэг хууль дээр суурилж, тус хуулиар зөвшөөрөл, мэдэгдлийн зохицуулалтыг тогтоон, улмаар тусгай салбарын хуулиудад (жишээлбэл, Эмийн бүтээгдэхүүний тухай хууль[5], Зэвсгийн тухай хууль[6]) тухайн салбарын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл шаардах, эмийн үйлдвэрлэл, эмийн бөөний худалдаа, зэвсэг сум худалдах, үйлдвэрлэх зэрэг үйл ажиллагааг тус тусын салбар хуулиар зохицуулдаг нь онцлог байна.

1.3. ГЕРМАН

Герман Улсад бизнес, худалдааны үйл ажиллагааг зохицуулдаг гол хууль нь Худалдааны зохицуулалтын тухай хууль[7] буюу (Gewerbeordnung (GewO)) юм. Хуулийн 1-р зүйлд худалдаа (бизнес) эрхлэх нь хүн бүрт зөвшөөрөгдөнө, гагцхүү энэхүү хуулиар (болон бусад холбогдох хууль тогтоомжоор) тусгай журам, хязгаарлалт тогтоосон тохиолдолд үйл ажиллагааг зөвшөөрөл авсны дагуу явуулах шаардлагатай гэж заажээ. Энэ нь худалдааны эрх чөлөөний үндсэн зарчим бөгөөд зөвхөн хуульд заасан тусгай нөхцөлд л уг эрх чөлөөг хязгаарлаж “зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагаа” гэж ангилжээ §1(1). Иймээс Германд ихэнхи нийтлэг төрлийн бизнес эрхлэхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй хэдий ч бүх бизнес эхлэгчид харьяа орон нутгийн захиргаанд үйл ажиллагаагаа заавал мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй байдаг (§14(1)). Энэ нь бизнесийн бүртгэлийн (*Gewerbeanmeldung*) мэдэгдэл бөгөөд уг мэдэгдлийг гаргаснаар тухайн этгээдийн үйл ажиллагаа албан ёсоор бүртгэгдэж, үүний дагуу эрх бүхий байгууллага (ихэвчлэн орон нутгийн худалдаа хяналтын газар) нь мэдэгдэл хүлээн авснаа гурван хоногийн дотор хариу мэдэгддэг байна(§15(1)).

Гэвч Германы хууль тогтоомжоор зарим онцгой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл эрхлэхийг шаардан, Худалдааны зохицуулалтын тухай хуулийн дагуу “тусгай зөвшөөрөл шаардлагатай худалдаа” гэж ангилсан. Тухайлбал, харуул хамгаалалтын үйлчилгээ (§34a), барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа (§34), дуудлага худалдааны үйл ажиллагаа (§34b), үл хөдлөх хөрөнгө зуучлал, зээлийн зууч, санхүүгийн зөвлөх үйлчилгээ (§34c, §34f, §34h), даатгалын зууч, зөвлөх үйлчилгээ (§34d), зоос ашигладаг автомат тоглоомын үйлчилгээ эрхлэх (§33c, §33d) зэрэг тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн этгээдийн

[5] Эстони: Medical Products Act. Хандах: *https://www.riigiteataja.ee/en/eli/511072014014/consolide#:~:text=,wholesale%20of%20medicinal*
[6] Эстони: Weapons Act. Хандах: *https://www.riigiteataja.ee/en/eli/504122014001/consolide*
[7] Герман: Gewerbeordnung. Хандах: *https://www.gesetze-im-internet.de/gewo/*

найдвартай байдал, санхүүгийн чадавх зэрэг нөхцөлийг шалгаж байж олгохоор хуульд заажээ (§33a-§34c). Харин дээрхээс бусад ихэнх бизнесийн төрлүүдийг чөлөөтэй эрхлэх боломжтой бөгөөд зөвхөн мэдэгдэл, бүртгэл хийлгэх үүрэг хүлээдэг байна (§14).

Герман Улс нь Засгийн газраас зөвшөөрөл олгох шийдвэр гаргахад хуульд заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд зөвшөөрлийг автоматаар олгогдсон гэж үзэх зохицуулалт нь онцлог байна (§6). Мөн тодорхой салбаруудын хувьд тусгай хуулиар нэмэлт зөвшөөрөл, бүртгэл хийлгэх зохицуулалт байдаг. Жишээ нь, Гар үйлдвэрийн тухай хуульд[8] зарим мэргэжлийн гар үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэхэд тухайн мэргэжлийн танхимд бүртгүүлж, эрх авах (гар үйлдвэрийн танхимын бүртгэл) шаардлагатай байдаг байна.

[8] Герман: Handwerksordnung. Хандах: *https://www.gesetze-im-internet.de/hwo/*

ХОЁР. УЛС ОРНУУДЫН (ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨС БУСАД) БҮРТГЭЛ, МЭДЭГДЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. ШИНЭ ЗЕЛАНД

Шинэ Зеландад бизнес эхлүүлэхэд нийтлэг, ерөнхий бизнесийн тусгай зөвшөөрөл шаарддаггүй, хэдий ч салбар тус бүрийн хууль тогтоомжид тусгагдсан бүртгэл, мэдэгдлийн шаардлагуудыг биелүүлэх үүрэгтэй байна. Тухайлбал, Компанийн тухай хуулийн[9] 13-р зүйлд зааснаар компанийн улсын бүртгэгч нь зөв зохистой бүрдүүлсэн бүртгэлийн өргөдлийг хүлээн авмагцаа компанийг албан ёсоор бүртгэж, үүсгэн байгуулсны гэрчилгээг олгох үүрэгтэй гэж тодорхойлсон байна. Мөн хуулиар компанийн бүртгэл хийлгэснээр компанийг үүсгэн байгуулсан гэж үзэхээр зохицуулжээ (§41).

Салбарын онцлогтой хууль тогтоомжууд бизнес эрхлэгчдэд нэмэлт бүртгэл, мэдэгдлийн үүрэг оноодог. Тухайлбал, Хүнсний тухай хуулийн[10] дагуу хоол хүнсний үйлчилгээ эрхлэх бүх аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа эхлэхдээ харьяалах орон нутгийн байгууллагад заавал бүртгүүлсэн байх шаардлагатай. Энэхүү хууль нь хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс өндөр эрсдэлтэй бизнесийг хатуу хяналттай, харин бага эрсдэлтэйг хялбаршуулсан горимоор ажиллуулах зохицуулалт хийсэн. Жишээ нь, дунд болон бага эрсдэлтэй хоол хүнсний бизнесүүд “үндэсний хөтөлбөр”-т хамрагдаж, тусгай төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй ч тухайн бизнесээ эрхлэхийн өмнө эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, стандарт мөрдөх, бүртгэл хөтлөх үүрэг хүлээдэг байна.

2.2. ЭСТОНИ

Эстони Улс зах зээлийн эдийн засгийн эрх чөлөөг хуульчилсан орон бөгөөд эдийн засгийн ямар ч үйл ажиллагааг эрхлэхийг нийтлэг зөвшөөрдөг. Гэхдээ олон нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдлын үүднээс тодорхой төрлийн үйл ажиллагаанд урьдчилан мэдэгдэх эсхүл үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах шаардлагыг хуульчилсан. Эдийн засгийн үйл ажиллагааны тухай хуулийн[11] 4-р зүйлд зааснаар, хэрэв тухайн бизнесийн үйл ажиллагааг мэдэгдлийн зохицуулалттай гэж салбарын хуульд тусгайлан заасан бол аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө эрх бүхий бүртгэлийн байгууллагад эдийн засгийн үйл ажиллагаа эхлүүлэх мэдэгдэл хүргүүлэх үүрэгтэй байна.

Аж ахуйн нэгжүүдийн талаар мэдээллийг төвлөрсөн бүртгэлд байлгах үүргийг мөн хуульчилсан. Эдийн засгийн үйл ажиллагааны тухай хуулийн 30-р зүйлд мэдэгдлийн хүрээнд бүртгэгдсэн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тодорхой хугацаанд багтаан шинэчлэх (өөрчлөлтийн мэдэгдэл хийх) үүргийг хүлээлгэсэн байдаг. Мөн тус хуулийн дагуу Эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэл хөтлөгдөж, бүх мэдэгдэл хүлээн авах эрх бүхий байгууллага (ихэнхдээ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, техникийн зохицуулалтын газар гэх мэт) түүнийг

[9] Шинэ Зеланд. Companies Act 1993. Хандах линк: https://www.legislation.govt.nz/act/public/1993/0105/latest/DLM320112.html
[10] Шинэ Зеланд. Food Act 2014. Хандах линк: https://www.legislation.govt.nz/act/public/2014/0032/75.0/DLM2995811.html
[11] Эстони. General Part of the Economic Activities Code Act. Хандах линк: https://www.riigiteataja.ee/en/eli/522082014004/consolide#:~:text=%C2%A7%201

хариуцан мэдээллийг хадгалдаг. Түүнчлэн Арилжааны тухай хууль[12] (Commercial Code) дагуу бүх хуулийн этгээдийг шүүхийн харъяалалтай Арилжааны бүртгэлд (Commercial Register) бүртгэдэг бөгөөд компани үүсгэн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл зэрэг нь олон нийтэд нээлттэй мэдээлэл болдог. Ийнхүү компанийн үндсэн бүртгэл (хуулийн этгээдийн бүртгэл) болон эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэл (тусгай зөвшөөрөл, мэдэгдлийн бүртгэл) нь харилцан уялдаатай ажиллаж, бизнесийн орчны ил тод байдлыг хангадаг.

2.3. ГЕРМАН

Герман Улс нь бизнес, худалдааны үйл ажиллагаанд худалдаа эрхлэх, эрх чөлөөний зарчим баримталдаг бөгөөд Худалдааны зохицуулалтын тухай хуулийн[13] хүрээнд иргэн хүссэн үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаагаа эрхлэх эрхтэй. Мөн тус хуулийн 14-р зүйлд "*Хэн нэгэн этгээд шинээр худалдаа, бизнесийн үйл ажиллагаа эхлэх, эсвэл салбар нэгж нээх, эсвэл бизнесийн үйл ажиллагааныхаа чиглэл, нэрийг өөрчлөх зэрэг тохиолдолд үүнийг харьяалах эрх бүхий байгууллагад (ихэвчлэн орон нутгийн худалдаа, нийтийн хэв журам хамгаалах алба) заавал мэдэгдэн бүртгүүлэх үүрэгтэй"* гэж заасан байдаг.

Мөн бизнес эрхлэхтэй холбоотой хоёр үндсэн бүртгэлийн тогтолцоо ажилладаг байна.

1. Дээр дурдсан Бизнесийн бүртгэл (Gewerbeanmeldung) буюу орон нутгийн захиргаанд мэдэгдсэнээр үүсэх худалдааны бүртгэл. Энэ нь төрийн байгууллагуудын дотоод хэрэглээнд чиглэсэн, бүх идэвхтэй бизнесийн мэдээллийн сан юм.
2. Хэрэв аж ахуйн нэгж нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувь нийлүүлсэн нийгэмлэг зэрэг хуулийн этгээдийн хэлбэртэй бол компаний мэдээллээ шүүхийн харьяанд хөтлөгддөг Арилжааны бүртгэлд (Handelsregister) бүртгүүлэх үүрэгтэй. Энэ нь олон нийтэд нээлттэй мэдээлэл бөгөөд компанийн дүрмийн сан, гүйцэтгэх захирлууд, компанийн хаяг зэрэг мэдээллийг агуулдаг. Харин арилжааны бүртгэл нь олон нийтэд нээлттэй бус, зөвхөн төрийн байгууллагууд ашигладаг (жишээлбэл, татвар, статистик, нийгмийн даатгалын байгууллагууд) мэдээллийн сан юм. Энэ хоёр бүртгэл нь үүрэг, зорилгоороо ялгаатай ч хоёул бизнесийн орчны ил тод байдлыг хангах, хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

[12] Эстони. Commercial Code. Хандах линк: https://www.riigiteataja.ee/en/eli/522062017003/consolide
[13] Герман. Gewerbeordnung-GewO. Хандах линк: https://www.gesetze-im-internet.de/gewo/

ГУРАВ. ЗӨВШӨӨРӨЛ ШААРДАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүснэгт 1. Улс орнуудын зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа, эрх олгогч байгууллага

Улс орон	Хууль, эрх зүйн үндэслэл	Үйл ажиллагааны төрөл (зөвшөөрөл шаардлагатай)	Зөвшөөрөл олгодог байгууллага	Тайлбар, хуульд заасан зүйл заалт
Шинэ Зеланд	Архи, согтууруулах ундаа худалдах, нийлүүлэх тухай хууль 2012 (Sale and Supply of Alcohol Act 2012)	Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа	Орон нутгийн Дүүргийн зөвшөөрлийн хороо (District Licensing Committee)	Согтууруулах ундааг худалдах, ресторан, баар ажиллуулахад тусгай зөвшөөрөл шаардлагатай (§7, 13). (Энэхүү зөвшөөрлийг орон нутгийн хороо хуульд заасан шалгуур (насны хязгаар, байрлал, цагийн хуваарь гэх мэт)-ын үндсэн дээр олгодог.)
	Хувийн аюулгүй байдлын ажилтнууд болон хувийн мөрдөн байцаагчдын тухай хууль (Private Security Personnel and Private Investigators Act 2010)	Хувийн хамгаалалт, мөрдөгчийн үйлчилгээ эрхлэх	Хувийн хамгаалалт, мөрдөгчийн лицензийн газар (Private Security Personnel Licensing Authority)	Хамгаалалтын алба, хувийн мөрдөгчийн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагатай (§23, 24). Лицензийн газар нь өргөдөл гаргагчийн шүүхийн түүх, ур чадварыг шалгаж тусгай зөвшөөрөл олгодог байна.
	Хоёрдогч худалдаачид ба барьцаалан зээлдүүлэх тухай хууль (Secondhand Dealers and Pawnbrokers Act 2004)	Барьцаалан зээлдүүлэх болон хуучин эд худалдах үйлчилгээ	Орон нутгийн цагдаагийн байгууллага	Ашигласан эд бараа худалдаалах, барьцаалан зээл олгох үйл ажиллагаа эрхлэхэд тусгай бүртгэл, зөвшөөрөл шаарддаг (§6, 9). (Мөн цагдаагийн байгууллага санхүүгийн сахилга бат, гэмт хэргийн түүхийг нягталж зөвшөөрөл олгодог байна.)
	Хүнсний тухай хууль (Food Act 2014)	Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ (хоолны газар, хүнсний үйлдвэр)	Орон нутгийн засаг захиргаа	Эрсдлийн түвшнээс хамаарч хүнсний бизнесийг орон нутгийн захиргаанд бүртгүүлэх буюу хяналт зохицуулалт хийлгэдэг. Өндөр эрсдэлтэй хүнсний үйл ажиллагаанд хүнсний хяналтын төлөвлөгөө батлуулах, бүртгүүлэх шаардлагатай (§31). (Харин бага эрсдэлтэй үйлчилгээний тухайд зөвхөн мэдэгдэл хийж бүртгүүлэх байдлаар явуулж болдог байна.)
Эстони	Зэвсгийн тухай хууль (Relvajahi seadus)	Галт зэвсэг, сумны худалдаа, үйлдвэрлэл	Эстонийн Цагдаагийн-Хилийн хамгаалалтын газар (Politsei- ja Piirivalveamet)	Зэвсгийн тухай хуулийн 66(1)-р зүйлд *“дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагатай: 1) галт зэвсэг, сум худалдах; 2) галт зэвсэг үйлдвэрлэх”* гэж заасан. Мөн тусгай зөвшөөрлийг Цагдаагийн байгууллага олгохдоо холбогдох аюулгүй байдал, найдвартай байдлын шалгуурыг үнэлдэг байна
	Эмийн тухай хууль (Ravimiseadus)	Эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний болон	Эрүүл мэндийн газар (Terviseamet)	Эмийн үйлдвэр ажиллуулах, эмийн сан эрхлэх зэрэгт үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авна. Тухайлбал, Эмийн хуульд

		жижиглэнгийн худалдаа (аптек)		*“дараах үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл шаардлагатай: 1) эмийн үйлдвэрлэл; 2) эмийн бөөний худалдаа; 3) эмийн сангийн үйл ажиллагаа”* гэж заасан (§30). (Мөн Эрүүл мэндийн газар нь мэргэжлийн шаардлага, байр талбай, тоног төхөөрөмжийн стандарт хангасан эсэхийг шалгаж зөвшөөрөл олгодог байна.)
	Эдийн засгийн үйл ажиллагааны тухай хууль (Majandustegevuse seadustiku üldosa seadus)	Зарим үйлчилгээний чиглэл (тусгай зөвшөөрөл шаардахгүй нь) – жишээ нь, ердийн худалдааны чиглэл, үйлчилгээ	Эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэл(Majandustegevuse register) – *мэдэгдэл хүлээн авах эрх бүхий байгууллага*	ЭЗҮАТХ-ийн дагуу шууд тусгай зөвшөөрөл шаардахгүй боловч мэдэгдэл хүргүүлж бүртгэлд орох үүрэгтэй олон үйл ажиллагаа байдаг. Жишээ нь, хүнсний бус ердийн жижиглэн худалдаа, зарим төрлийн үйлчилгээ г.м. Эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэлд бүртгүүлээд үйл ажиллагаагаа эхэлдэг §5(4). (Энэ тохиолдолд тусгай зөвшөөрөл олгодог байгууллага байхгүй, харин бүртгэлийг хариуцсан байгууллага (ихэвчлэн салбарын яамны харьяа агентлаг, эсвэл орон нутгийн захиргаа) мэдэгдлийг хүлээн авч, шаардлагатай бол хяналт тавина.)
Герман	Худалдааны зохицуулалтын тухай хууль (Gewerbeordnung (GewO))	Хувийн хамгаалалтын (үйлчилгээ	Мужийн Захиргааны газар (зарим мужид цагдаагийн байгууллага)	Хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхэд хуулийн 34а-р зүйлийн дагуу тусгай зөвшөөрөл (эрх) авах ёстой. Энэ зөвшөөрлийг орон нутгийн захиргааны харьяа олгодог. Зөвшөөрөл авахад компаний удирдах хүний найдвартай байдал (шүүхийн түүхгүй, санхүүгийн өр төлбөргүй гэх мэт) болон мэргэжлийн мэдлэгийг шалгасан байна §34а(1). (Түүнчлэн хамгаалалтын ажилтнуудад тусгай шалгалт (Sachkundeprüfung) өгсөн байх шаардлага тавьдаг байна.)
		Үл хөдлөх хөрөнгө зуучлах, зээлийн зууч, барилгын төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ	Мужийн Захиргааны газар (зарим тохиолдолд Худалдааны танхимаар дамжуулан)	Тус хуулийн 34с-р зүйлд зуучлалын үйлчилгээг эрхлэхэд тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг. Зөвшөөрөл олгохдоо татвар, зээл төлбөрийн өргүй, гэмт хэрэг үйлдээгүй эсэх болон санхүүгийн чадавх (өр төлбөргүйг нотлох баримт) зэргийг шалгана (§34с(2)). Зөвшөөрлийг ихэвчлэн орон нутгийн эрх бүхий байгууллага олгодог боловч тодорхой мужид (Худалдааны танхим энэ үүргийг гүйцэтгэж болно.)

		Ерөнхий худалдааны үйл ажиллагаа (зөвшөөрөл шаардлагагүй бизнесийн ихэнх төрөл)	Орон нутгийн Худалдаа бүртгэлийн газар (Gewerbeamt)	Зөвшөөрөл шаардлагагүй ч мэдэгдэл, бүртгэл хийх үүрэгтэй үйл ажиллагааны жишээ бол ихэнх жижиглэн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн бизнесүүд юм. Хуулийн 14-р зүйлд зааснаар ямар ч бие даасан бизнес эрхлэгч үйл ажиллагаагаа эхлэхдээ засаг захиргаанд мэдэгдэж, бүртгүүлэх ёстой. Энэ мэдэгдлийг хүлээн авч, худалдаа бүртгэлийн газар нь хуулийн 15-р зүйлд заасны дагуу хүлээн авснаа мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв уг мэдэгдлийг хийлгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол эрх бүхий байгууллага үйл ажиллагааг нь зогсоох эрхтэй (§15(2)). Мөн уг зөрчил нь захиргааны зөрчилд тооцогдож 5,000 хүртэл евро торгууль ногдуулах боломжтой байна §144.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА: ЗӨВШӨӨРӨЛ ШААРДСАН САЛБАР ДАХЬ ЗӨРЧИЛ

4.1. ШИНЭ ЗЕЛАНД

Шинэ Зеландад тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр явуулсан тохиолдолд холбогдох салбарын хуульд заасан эрх зүйн хариуцлага хүлээлгэнэ. Ихэнх тохиолдолд энэ нь эрүүгийн зөрчил буюу гэмт хэрэгт тооцогдох ба торгууль, үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг авахаар хуульчилсан байдаг. Жишээлбэл:

- **Архи, согтууруулах ундаа худалдах зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн** бол Архи согтууруулах ундаа худалдах, нийлүүлэх тухай хуулийн дагуу гэмт хэрэгт тооцож, өндөр мөнгөн торгууль ногдуулах буюу шүүхээс шийтгэл оногдуулна (§233, §236).

- **Хамгаалалтын үйлчилгээний тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах** нь Хувийн аюулгүй байдлын ажилтнууд болон хувийн мөрдөн байцаагчдын тухай хуулийн зөрчил болж, уг хуулийн 63-р зүйлд зааснаар торгууль ногдуулах, давтан үйлдвэл хорих ялаар шийтгэх байна.

- **Бусад зөвшөөрөлгүй үйл ажиллагаа**: Тухайн салбарын хуулиудад (жишээлбэл, Хүнсний тухай хууль гэх мэт) зөвшөөрөл, бүртгэлийн шаардлагыг зөрчсөн бол зөрчлийн торгууль, зарим ноцтой тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Мөн зөвшөөрөлгүйгээр олсон ашиг орлогыг хураах, үйл ажиллагааг зогсоох захирамж гаргах зэрэг арга хэмжээ авах эрхийг хууль эрх бүхий байгууллагад олгосон байдаг.

Нэмж дурдахад, Шинэ Зеландын хууль тогтоомжид хууль бус үйл ажиллагааны иргэний эрх зүйн үр дагавар мөн үүсдэг. Жишээ нь, зөвшөөрөлгүй үйлчилгээ үзүүлсэн этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл нь хүчингүйд тооцогдох, хэрэглэгч хохирсон тохиолдолд хохирлоо нэхэмжлэх нөхцөл бүрдэнэ. Иймд бизнес эрхлэгчид хуульд заасан зөвшөөрөл, бүртгэлийн шаардлагыг биелүүлэх нь хариуцлагаас урьдчилан сэргийлэх чухал үндэс болдог бөгөөд зохицуулалт нь голчлон салбар тус бүрийн хуулиар торгууль, шийтгэлийг нарийвчлан зааж өгдөг онцлогтой байна.

4.2. ЭСТОНИ

Эстонийн Эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий хууль (ЭЗҮАЕХ) болон холбогдох салбарын хуулиудаар зөвшөөрөлгүй буюу мэдэгдэлгүй хууль бусаар үйл ажиллагаа явуулсан этгээдэд эрх зүйн хариуцлага оногдуулахаар тусгасан. Тухайлбал, уг хуулийн 75-р зүйлд *“зөрчил гаргагч (аж ахуйн нэгж) нь санаатайгаар худал мэдээлэл төрийн байгууллагад өгсөн бол 300 нэгж хүртэлх торгууль, хуулийн этгээдийн хувьд 3000 евро хүртэл торгууль ногдуулна”* гэж заасан. Мөн тус хуульд заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй, мэдэгдэл гаргаагүй зэрэг үйлдэл нь зөрчилд тооцогдож, энэ төрлийн зөрчил шалган шийтгэх эрхийг холбогдох хяналтын байгууллагад олгодог байна (§74).

Гэвч ЭЗҮАЕХ нь ерөнхий зохицуулалттай тул тодорхой үйл ажиллагааг зөвшөөрөлгүй явуулсан тохиолдлын шийтгэлийг ихэвчлэн салбарын тусгай хууль тус бүрд нь заадаг. Жишээлбэл:

- **Зэвсгийн тухай хуульд** тусгай зөвшөөрөлгүйгээр зэвсгийн худалдаа эрхэлсэн бол эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэн, торгууль, баривчлах, ял шийтгэл оноох зохицуулалттай байна (§113, §114).

- **Эмийн тухай хуульд** зөвшөөрөлгүй эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлбэл торгууль ногдуулахаас гадна үйл ажиллагааг зогсоох, бүтээгдэхүүнийг хураах арга хэмжээ авдаг байна.

- **ЭЗҮАТХ-д заасан мэдэгдэл, бүртгэлийн үүргээ биелүүлээгүй** бол тус хуулийн 76-р зүйлд зааснаар өргөдлийг хугацаанд нь гаргаагүй, эсхүл татгалзсан тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болдог байна.

Эстонийн хяналтын байгууллагууд (салбарын яамд, агентлагууд) нь зөвшөөрөлгүй үйл ажиллагаанд төрийн хяналтын арга хэмжээ авч, шаардлагатай бол захиргааны актаар үйл ажиллагааг нь зогсоох буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох шийдвэр гаргах эрхтэй байдаг (ЭЗҮЕХ, §55). Өөрөөр хэлбэл, тус улсад зөвшөөрөл, мэдэгдлийн журмыг зөрчсөн нь хууль ёсны үр дагавартай бөгөөд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн болон үйл ажиллагааны хориг оногдуулдаг. Энэ нь зөвшөөрлийн тогтолцооны найдвартай ажиллагааг хангах механизмуудын гол хэлбэр юм.

4.3. ГЕРМАН

Германд тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр (эсвэл бүртгэл, мэдэгдэл хийлгүйгээр) явуулбал хууль зөрчсөн үйлдэл (захиргааны зөрчил (Ordungswidrigkeit))-д тооцож, хариуцлага хүлээлгэдэг байна. Худалдааны зохицуулалтын тухай хуулийн 15(2)-р зүйлд *“хэрэв тусгай зөвшөөрөл шаардлагатай худалдааг зөвшөөрөлгүй эрхэлж байвал эрх бүхий байгууллага үйл ажиллагааг нь үргэлжлүүлэхээс сэргийлэх (зогсоох) арга хэмжээ авна”* гэж заасан байдаг. Энэ нь ямар нэгэн зөвшөөрөлгүй ажилласан компани, хувь хүний бизнесийг албадан зогсоох эрх, орон нутгийн захиргаанд байгааг илэрхийлдэг байна.

Мөн Германы хуульд ийм үйлдлийг захиргааны зөрчил буюу эрүүгийн хэрэг хэмээн үзжээ. Тухайлбал, Худалдааны зохицуулалтын тухай хуулийн 144-р зүйлээр зөрчил гаргавал ямар торгууль оногдуулахыг нарийвчлан тусгасан. Тухайн зөрчилд оногдуулах торгуулийн дээд хэмжээг ихэнх зөрчилд 5,000 евро хүртэл, зарим ноцтой тохиолдолд (жишээ нь, үнэт цаас, санхүүгийн чиглэлийн зөвшөөрөлгүй үйлчилгээ) 50,000 евро хүртэл торгууль ногдуулж болно гэж заасан байна.

Хэрэв зөвшөөрөлгүй үйл ажиллагааны явцад хүний амь нас, аюулгүй байдал, олон нийтийн ашиг сонирхолд ноцтой хохирол учирсан, эсвэл санхүүгийн томоохон зөрчил илэрсэн бол эрүүгийн хэргийн шинжтэй гэж үзэн Эрүүгийн хуулиар зохицуулдаг байна. Жишээлбэл, эмийн зөвшөөрөлгүй худалдаа, галт зэвсгийн зөвшөөрөлгүй арилжаа зэрэг багтана.

Эрх бүхий байгууллагууд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буйг илрүүлбэл:

- Нэн түрүүнд үйл ажиллагааг таслан зогсоох буюу үйл ажиллагаа эрхлэхийг хориглох шийдвэр гаргаж, биелэлтэнд хяналт тавина (GewO §15(2))

- Зөрчлийн шинжтэй бол захиргааны журмаар торгууль ногдуулж, энэхүү торгуулийг Захиргааны зөрчлийн хууль[14] (Gesetz über Ordnungswidrigkeiten)-ийн дагуу барагдуулна.
- Давтан болон санаатай ноцтой зөрчил гаргасан этгээдийн хувьд тухайн этгээдийг найдвартай бус гэж үзэн Худалдааны зохицуулалтын тухай хуулийн 35-р зүйлийн дагуу бизнес эрхлэх эрхийг нь хасах шийдвэр гаргаж, компанийн эзэмшигч бүх төрлийн бизнес эрхлэхийг хүртэл хориглож, хатуу арга хэмжээ авдаг байна.
- Зөрчилтэй холбогдуулан, олсон орлогыг хураах буюу улсын орлого болгох зохицуулалттай байна (GewO §144(4)).
- Мөн салбарын хуулиудаар зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан байна.

Товчхондоо, Герман Улсад зөвшөөрлийн журам зөрчигчдөд торгууль болон үйл ажиллагааны хориг зэрэг хариуцлагын механизм үйлчилдэг бөгөөд энэ нь тус улсын зөвшөөрлийн тогтолцооны хэрэгжилтийг хангах гол хэрэгсэл болдог. Зөвшөөрөлгүй үйл ажиллагааг илрүүлэх үүргийг орон нутгийн захиргаа, холбогдох хяналтын байгууллагууд (жишээ нь, татварын алба, цагдаа) хуулиар хүлээдэг ба эдгээр байгууллага харилцан мэдээлэл солилцож зөрчлийг шалгана (GewO §16,§14(5)).

[14] Герман. Gesetz über Ordnungswidrigkeiten. Хандах линк: https://www.buzer.de/gesetz/5827/index.htm

ТАВ. УЛС ОРНУУДЫН ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

Гурван улсын зөвшөөрлийн эрх зүйн орчны нийтлэг шинж нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, эрсдэл бүхий салбарт төрийн хяналт тогтоох, эдийн засгийн үйл ажиллагааны суурь эрх чөлөөг хүндэтгэх гэсэн зорилтыг хуульчилсан явдал юм. Харин эдгээр зорилгыг хэрэгжүүлэх арга, механизмаар ялгарах бөгөөд, жишээлбэл Шинэ Зеланд нь салбар тус бүрийн хуульд тулгуурласан зохицуулалттай. Эстони нь бүх салбарыг хамарсан нэгдмэл суурь хуультай төдийгүй цахимжсан шийдэлд тулгуурласан. Герман нь нарийвчилсан, уламжлалт, иж бүрэн зохицуулалт бүхий эрх зүйн орчинтой хэдий ч, зөвшөөрөл болон бүртгэлийн шаардлагыг биелүүлэх нь тухайн бизнесийн хууль ёсны үйл ажиллагаа эрхлэх үндсэн нөхцөл болно. Зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбоотой зөрчилд эрх зүйн хариуцлага хүлээлгэдэг байдал нийтлэг байна.

Шинэ Зеланд – Тус улсад бүх төрлийн бизнесийг хамарсан нэг нийтлэг “тусгай зөвшөөрлийн хууль” байдаггүй, харин эрх чөлөөтэй бизнес эрхлэлтийг үндсэн зарчим болгож, зөвхөн тодорхой өндөр эрсдэлтэй салбаруудад л тусгай зөвшөөрөл олгох шаардлага тавьдаг. Ингэхдээ тусгай зөвшөөрөл, бүртгэлийн шаардлагуудыг тухайн салбарын хуулиудад нарийвчлан тусгаж, хяналт шалгалтыг салбарын мэргэшсэн байгууллагад харьяалуулдаг. Энэ төвлөрсөн бус арга нь бизнес эхлүүлэх процессыг хялбар, хурдан болгож, зөвхөн зайлшгүй тохиолдолд төрийн оролцоог нэмэгдүүлэх давуу талтай байна. Үүний зэрэгцээ бизнесийг бүртгэх замаар албан ёсны мэдээллийн сан бүрдүүлж, хариуцлагын болон татварын орчныг хамтад нь зохицуулдаг. Шинэ Зеландад орон нутгийн засаг захиргааны үүрэг өндөр байдаг буюу тусгай зөвшөөрлийг (жишээлбэл, архи худалдах г.м) орон нутгийн байгууллага шийдвэрлэдэг ба энэ нь төвлөрлийг сааруулсан зохицуулалтын жишээ юм.

Эстони – Зөвшөөрлийн орчны хамгийн онцлох шинж нь нэгдсэн систем, цахим интеграцчилал юм. Эдийн засгийн үйл ажиллагааны тухай хууль нь эдийн засгийн бүхий л үйл ажиллагаанд хамаарах ерөнхий суурь дүрмийг тогтоосон бөгөөд зөвшөөрөл (tegevusluba), мэдэгдэл (teatis), бүртгэл (register) зэрэг ойлголтыг нэг хуульд системтэйгээр зохицуулалттай байна. Үүний зэрэгцээ Эстони улс цахим засаглалыг идэвхтэй нэвтрүүлж, цахим хуудас (Eesti Teabevärav)-аар дамжуулан аж ахуйн нэгжүүд онлайнаар мэдэгдэл, зөвшөөрлийн хүсэлтээ өгч, хариу мэдээлэл авдаг болсон. Нэг цонхны зарчмаар олон салбарын мэдээллийг тус вебсайтаас авч болдог ба ямар үйл ажиллагаанд зөвшөөрөл шаардлагатай, аль нь зөвхөн мэдэгдэл хангалттайг нэг дороос мэдэх боломжтой. Мөн Европын Холбооны үйлчилгээний бодлогын захирамжийг[15] хуульдаа тусгасан бөгөөд үйлчилгээний чиглэлээр гадаадынханд үйл ажиллагаа эрхлэхэд хялбар нөхцөл олгох (шаардлага давхардуулахгүй байх, эх оронд нь авсан зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөх гэх мэт) заалтууд Эдийн засгийн үйл ажиллагааны тухай хуульд[16] туссан байдаг)§4-6, §9, §10, §11, §22.1-22.6).

---

[15] EX. DIRECTIVE 2006/123/EC. Хандах линк: *https://eur-lex.europa.eu/eli/dir/2006/123/oj/eng*

[16] Эстони. Majandustegevuse seadustiku üldosa seadus. *https://www.riigiteataja.ee/akt/125032011001#:~:text=,nimi%2C%20isikukood%2C%20selle%20puudumise%20korral*

Герман – Тус улсын Худалдааны зохицуулалтын тухай хуулийн 1-р зүйлээр худалдаа (бизнес) эрхлэх нь хүн бүрт зөвшөөрөгдөнө гэсэн үндсэн зарчимтай. Энэ зарчмын хүрээнд бүх бизнес эрхлэгч нийтлэг нэг шугамаар орон нутгийн захиргаанд мэдэгдэл хүргүүлдэг нь зохицуулалтын нийтлэг суурь шаардлага болно (GewO §14). Германд онцлог нь салбарын хуулиар (банк, даатгал, хөдөлмөр хамгаалал, байгаль орчин, барилга байгууламж, гар үйлдвэрлэл, эмчилгээ үйлчилгээ) тусгай зөвшөөрөл, бүртгэлийг зохицуулдаг. Мөн Европын Холбооны бодлогын хүрээнд зөвшөөрлийн явцыг хялбаршуулах алхмууд хийсэн.Тухайлбал, эрх бүхий байгууллага тогтоосон хугацаанд шийдээгүй бол зөвшөөрлийг автоматаар олгосонд тооцох зэрэг шинэлэг зохицуулалт нэвтрүүлсэн байна (GewO §6a).

Нэг цэгийн үйлчилгээний газар бий болгож, зөвшөөрөл, бүртгэлийн өргөдлийг авч, холбогдох байгууллагуудад шилжүүлэх замаар аж ахуйн нэгжид чирэгдэл багасгахыг зорьсон (GewO §6b). Найдвартай байдлын шалгуур маш чухал байр суурь эзэлдэг бөгөөд бизнес эрхлэх аж ахуйн нэгжийн эзэмшигчийн санхүүгийн чадвар, гэмт хэрэгт зөрчилгүй байдал зэргийг нарийвчлан хянадаг. Хэрэв эдгээрт харшилсан нөхцөл илэрвэл зөвшөөрлийг хүчингүй болгож, цаашлаад тухайн этгээдийг бүхэлд нь бизнес хийхийг хориглох хүртэл арга хэмжээ авдаг (GewO §35). Энэ нь нэг талаас бизнесийн орчны найдвартай, шударга байдлыг хангах ч нөгөө талаас захиргааны хяналт өндөр болохыг илтгэдэг байна.

Bundesministerium der Justiz. (2024). *Gewerbeordnung (GewO) – Untersagung wegen Unzuverlässigkeit*. Buzer.de. Retrieved June 26, 2025, from https://www.buzer.de/35_GewO.htm

International Trade Administration. (2023, November 21). *New Zealand - Licensing requirements for professional services*. U.S. Department of Commerce. Retrieved June 26, 2025, from https://www.trade.gov/country-commercial-guides/new-zealand-licensing-requirements-professional-services

LegalVision. (n.d.). *How to obtain a business licence in New Zealand*. LegalVision New Zealand. Retrieved June 26, 2025, from https://legalvision.co.nz/regulatory-and-compliance/business-licence-nz/

New Zealand Government. (1993). *Companies Act 1993*. New Zealand Legislation. Retrieved June 26, 2025, from https://www.legislation.govt.nz/act/public/1993/0105/latest/DLM319570.html

New Zealand Government. (2010). *Private Security Personnel and Private Investigators Act 2010*. New Zealand Legislation. Retrieved June 26, 2025, from https://www.legislation.govt.nz/act/public/2010/0115/latest/DLM1594432.html

New Zealand Government. (2012). *Sale and Supply of Alcohol Act 2012*. New Zealand Legislation. Retrieved June 26, 2025, from https://www.legislation.govt.nz/act/public/2012/0120/latest/DLM3339333.html

Riigikogu. (2011). *Majandustegevuse seadustiku üldosa seadus* [General Part of the Economic Activities Code Act]. Riigi Teataja. Retrieved June 26, 2025, from https://www.riigiteataja.ee/akt/125032011001